



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/518

Алтай хот

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн Улсын үзлэгийг эрчим хүчний салбарт 2021 оны 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.

2.Улсын үзлэгийг заагдсан хугацаанд чанартай зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай .

3.Үзлэг зохион байгуулахад шаардагдах 610,000 (зургаан зуун арван мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР